

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛДААН – Хуралдааны тойм

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛДААНААР ХЭЛЭЛЦСЭН АСУУДЛЫН ХӨТӨЛБӨР №21

Хуралдаан 2013 оны зургадугаар сарын 27-ны өдрийн 14 цаг 05 минутад эхэлж, 15 цаг 45 минут хүртэл Төрийн албаны зөвлөлийн хуралдааны танхим (Засгийн газрын 11 дүгээр байрны 301 тоот өрөө)-д болж, нийт 1 цаг 40 минут үргэлжлэв.

№	Хэлэлцсэн асуудал	Гарсан шийдвэр
1	<p>Гаалийн ерөнхий газрын дэд дарга нарын албан тушаалд томилуулахаар санал болгосон албан хаагчид Төрийн албаны зөвлөлийн дүгнэлт гаргаж, нэр дэвшүүлэх тухай</p> <ul style="list-style-type: none">- Гаалийн хяналтын асуудал хариуцсан дэд дарга- Татвар, тарифны асуудал хариуцсан дэд дарга	<p>Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, 35 дугаар зүйлийн 35.1.6 болон Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 14-ийн “а”-д заасныг тус тус баримталж, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <p>Гаалийн ерөнхий газрын Гаалийн хяналтын асуудал эрхэлсэн дэд даргын албан тушаалд Найдангийн Энхцогтод дүгнэлт гарган нэр дэвшүүлж, Гаалийн ерөнхий газрын дарга О.Ганбатад санал болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p> <p>Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, 35 дугаар зүйлийн 35.1.6 болон Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 14-ийн “а”-д заасныг тус тус баримталж, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <p>Гаалийн ерөнхий газрын Татвар,</p>

		тарифын асуудал эрхэлсэн дэд даргын албан тушаалд Цогоогийн Уугангэрэлд дүгнэлт гарган нэр дэвшүүлж, Гаалийн ерөнхий газрын дарга О.Ганбатад санал болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.
2	Нийслэл, аймаг дахь Төрийн албаны зөвлөлийн Салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн баталж, Салбар зөвлөлийн дарга, нарийн бичгийн даргыг томилох тухай	Аймаг дахь Салбар зөвлөлийг Салбар зөвлөлийн бүрэлдэхүүний нийтлэг жишгийн дагуу байгуулсан эсэхийг нягтлах, зарим аймаг Салбар зөвлөлийн бүрэлдэхүүний нийтлэг жишигт нийцүүлэн Салбар зөвлөлөө дахин байгуулах шаардлагатай байгаа тул уг асуудлыг дараагийн хуралдаан хүртэл хойшлуулахаар тогтов.
3	Зам тээврийн яамны Зам тээврийн хяналт, бүртгэлийн газрын мэргэжилтнээр ажиллаж байсан Р.Саруулаас гаргасан гомдлын талаарх Маргаан хянан шалгах комиссын дүгнэлтийн тухай	<p>Төрийн албаны тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1.1, Улсын Их Хурлын 2003 оны 14 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн байгууллага болон төрийн жинхэнэ албан хаагч, уг албан тушаалд нэр дэвшигчийн хооронд төрийн албатай холбогдсон асуудлаар гарсан маргааныг хүлээн авч, хянан шийдвэрлэх журам”-ын 6, Төрийн албаны зөвлөлийн 06 дугаар сарын 27-ны өдрийн хуралдааныг шийдвэрийг тус тус үндэслэн:</p> <p>1. “Ажлаас чөлөөлөх тухай” 2013 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн 142 дугаар тушаалыг хууль зүйн үндэслэлтэй гэж үзсэн Зам, тээврийн яамны дэргэдэх Төрийн албаны зөвлөлийн Салбар зөвлөлийн “Маргаан хянан шалгах комиссын дүгнэлтийн тухай” 2013 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн 06 дугаар тогтоолыг хүчингүй болгох тухай Маргаан хянан шалгах комиссын дүгнэлтийг зүйтэй гэж үзэх.</p> <p>2. “Ажлаас чөлөөлөх тухай” Зам, тээврийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2013 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн 142 дугаар тушаалыг хүчингүй</p>

		<p>болгож шийдвэрлэхийг Зам, тээврийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Батзаяад үүрэг болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
4	<p>Бусад асуудал: Говьсүмбэр, Увс, Булган, Өмнөговь, Дундговь, Архангай, Дархан-Уул аймагт зохион байгуулсан төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоог нөхөх зорилго бүхий төрийн албаны мэргэшлийн шалгалтын дүн, уг шалгалтад тэнцсэн иргэдийг төрийн жинхэнэ албанд анх орох иргэний нөөцийн жагсаалтад бүртгэж, хамгийн өндөр оноо авсан иргэдийг өрсөлдсөн албан тушаалд нэр дэвшүүлэх тухай</p>	<p>Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3, Төрийн албаны зөвлөлийн 2009 оны 63 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалт авах журам”-ын 56 дугаар зүйлийг баримталж, 2013 оны 06 дугаар сарын 12-19-ний өдрүүдэд Говьсүмбэр, Увс, Булган, Өмнөговь, Дундговь, Архангай, Дархан-Уул аймагт тус тус зохион байгуулсан Төрийн албаны мэргэшлийн шалгалтад тэнцсэн иргэдийг төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцөд бүртгүүлэх тухай Төв комиссын саналыг хэлэлцсэн Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <p>1. Говьсүмбэр, Увс, Булган, Өмнөговь, Дундговь, Архангай, Дархан-Уул аймагт 2013 оны 06 дугаар сарын 12-19-ний өдрүүдэд зохион байгуулсан төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалтад тэнцсэн нийт 378 иргэнээс 274 иргэнийг “Дэс түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д, 104 иргэнийг “Туслах түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д бүртгэснийг 1, 2, 3, 4, 5, 6, 7, 8, 9, 10, 11, 12, 13 дугаар хавсралтаар тус тус батлах.</p> <p>2. Энэхүү тогтоолын нэг дэх хэсэгт заасан “Дэс түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д бүртгэгдсэн иргэдээс хамгийн өндөр оноо авсан нэр бүхий 84 иргэнийг, “Туслах түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д бүртгэгдсэн иргэдээс хамгийн өндөр оноо авсан нэр бүхий 21</p>

		<p>иргэнийг өрсөлдсөн албан тушаалд нь томилуулахаар нэр дэвшүүлж, нэрсийг 14, 15, 16, 17, 18, 19, 20, 21, 22, 23, 24, 25, 26 дугаар хавсралтаар тус тус батлах.</p> <p>3. Энэхүү тогтоолын 14-26 дугаар хавсралтаар баталсан нэр бүхий 105 иргэнийг “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль”-ийн 23 дугаар зүйлийн 23.5, Төрийн албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.1-д заасан шаардлагыг баримтлан, тухайн албан тушаалд томилуулах арга хэмжээ авахыг Говьсүмбэр, Увс, Булган, Өмнөговь, Дундговь, Архангай, Дархан-Уул аймаг дахь Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн даргад үүрэг болгох.</p> <p>4. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн албаны зөвлөлийн гишүүн Т.Хадхүүд даалгах тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
--	--	---

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ